

Агуулга

ОРШИЛ

ТОВЧ ТАЙЛБАР, ТОДОРХОЙЛОЛТ

НЭГ. Малчдын тоо тэдний соёл ахуйн үзүүлэлт

I.1. Малчдын тоо, насны бүтэц

I.1.2 Малчдын соёл ахуйн үзүүлэлт

ХОЁР. Малын тоо, түүний бүтэц, бүрэлдэхүүн

II.1. Малын тоо бүтэц

II.2. Хувийн /амины/ малын тоо бүтэц

II.3. Малтай өрхийн малын бүлэглэлт

II.4. Хээлтэгч мал

II.5. Төл бойжилт

II.6. Том малын зүй бусын хорогдол

II.7. Малын хээл хаялт, сувайралт

II.8. Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо

II.9. Малын хэрэглээний зарлага

II.10. Сүргийн бүтэц

II.11. Цэвэр үүлдрийн болон эрлийз малын тоо

ГУРАВ. Малын бэлчээр, тэжээлийн хүрэлцээ, хангамж

III.1. Бэлчээрийн хүрэлцээ

III.2. Малын тэжээлийн үйлдвэрлэлт

III.3. Тэжээлийн бүтэц, тэжээлийн хангамж

ДӨРӨВ. Тэжээвэр амьтан

IV .1 Тэжээвэр амьтдын тоо

ДҮГНЭЛТ

ХАВСРАЛТУУД

Оршил

Өмнөговь аймгийн эдийн засгийн хөгжилд Хөдөө аж ахуйн салбар өнөөг хүртэл тэргүүлэх байр суурийг эзэлсээр ирсэн бөгөөд цаашид ч мөн уул уурхайн салбарыг даган эрчимтэй хөгжүүлэх бодлого чиглэлийг баримталж байна.

Хөдөө аж ахуйн салбарын үйл ажиллагаа нь бусад хүчин зүйлээс илүүтэйгээр байгаль, цаг агаараас хамааралтай бөгөөд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн нь үндсэндээ хүн амын хүнсний хэрэглээ, боловсруулах үйлдвэрлэлийн болон үйлчилгээний салбарын түүхий эдийн хэрэглээг хангахад чиглэгддэг.

“Монгол Улсын Үндсэн хууль”-д “Мал сүрэг”-ийг үндэсний баялаг мөн гэж хуульчлан зааж, мал тооллогыг улсын хэмжээнд жил бүр зохион байгуулж, үр дүнг нь макро түвшинд хийгддэг тооцоо, судалгаанд ашиглаж, салбарын талаар удирдлагын шийдвэр гаргах мэдээллийн гол эх үүсвэр болгон ашиглаж байна.

“Статистикийн тухай” Монгол Улсын хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2003 оны 224 дүгээр тогтоолын дагуу Үндэсний Статистикийн хороо мал, тэжээвэр амьтад, тэжээлийн тооллогыг 2012 оны 12 сарын 7-ноос 17-ны өдрүүдэд улсын хэмжээнд зохион байгуулж явууллаа.

2012 оны хувьд мал тооллогын холбогдолтой маягт зааварт өөрчлөлт орсон бөгөөд мал тооллогын программ цахим хэлбэрт шилжсэнээр мэдээлэл технологийн дэвшилтэд хүрч, цаг хугацааг хэмнэж мэдээллийн тархаалт шуурхай болсон нь ололттой талууд бий болж байгаа юм.

Энэхүү танилцуулгад малын 2012 оны тооллогын дүнг нэгтгэн дүгнэснээс гадна мал аж ахуйн салбарын бүтээгдэхүүн, шинээр гаргасан, сэргээн засварласан худаг, уст цэг, малжуулалтын талаарх мэдээллийг тусган орууллаа. Түүнчлэн газар тариалангийн салбарын үндсэн үзүүлэлтүүд болох тариалсан талбай, хураасан ургац, га-гийн ургацын талаарх мэдээллийг жилийн дүнгээр нэгтгэн тусгасан болно.

Манай аймгийн хөдөө аж ахуйн салбарын өнөөгийн байдалд дүгнэлт хийж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг боловсруулах, төлөвлөхөд энэхүү танилцуулга, судалгааны материал суурь мэдээлэл нь болно гэдэгт итгэж байна.

НЭР ТОМЬЁОНЫ ТОВЧ ТАЙЛБАР, ТОДОРХОЙЛОЛТ

Малтай өрх. Малыг ахуй амьдралдаа туслах чанарын үүрэгтэй өсгөн үржүүлдэг өрх
Малчин өрх. Жилийн 4 улирлын туршид малаа маллаж, малын ашиг шим нь тэдний амьжиргааны эх үүсвэр нь болж байгаа өрх

Малчид. Жилийн 4 улирлын туршид мал аж ахуй эрхэлж, малын ашиг шим нь тэдний амьжиргааны эх үүсвэр болж байгаа 16 ба түүнээс дээш насны хүмүүсийг хэлнэ.

Бодод шилжүүлэх коэффициент:

1 адуу, үхэр - 1 бод
1 тэмээ - 1.5 бод
6 хонь - 1 бод
8 ямаа - 1 бод

Бодод шилжүүлэх коэффициентийг таван төрлийн малыг нэг төрлийн малд шилжүүлэн малын өсөлт, бууралтыг гаргах, үр ашгийг тооцоход ашиглана.

Бог малд буюу хонин толгойд шилжүүлэх коэффициент:

1 тэмээ - 5 хонь
1 адуу - 7 хонь
1 үхэр - 6 хонь
1 хонь - 1 хонь
1 ямаа - 0.9 хонь

Бог-д шилжүүлэх коэффициентийг малын тэжээлийн хүрэлцээ, хангамж, бэлчээрийн даацыг тодорхойлон гаргахад ашиглана.

Нас гүйцсэн мал. Малын төрөл бүр дээр дараах насны малыг хамруулна.

Тэмээ - 4 настай, 5 ба түүнээс дээш настай

Адуу - 3 настай, 4 ба түүнээс дээш настай

Үхэр - 2 настай, 3 ба түүнээс дээш настай

Бог мал - тухайн жилийн төл малаас бусад насны мал

Өсвөр насны мал

Тэмээ-Өмнөх оны төл, 2, 3 настай

Адуу- Өмнөх оны төл, 2 настай

Үхэр- Өмнөх оны төл

Төл мал. Тухайн жилийн төлийг хэлнэ.

Бэлэн хээлтэгч. Малын төрөл бүр дээр нас гүйцсэн эм малыг хамруулна.

Малын тоо, толгойн өсөлт. Оны эцсийн малаас оны эхний малыг хасч, малын тооны өөрчлөлтийг тоогоор илэрхийлнэ. Оны эцсийн малын тоог оны эхний малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлж, өсөлт, бууралтыг хувиар илэрхийлнэ.

Малын өсөлтийн **орлого тал** нь төл бойжилт, **зарлага тал нь** хэрэглээний зарлага, том малын зүй бус хорогдол байна.

Төллөлтийн хувь. Төллөсөн хээлтэгчийн тоог оны эхний хээлтэгчийн тоонд харьцуулан, 100 –гаар үржүүлэн тооцно.

Бойжилтын хувь. Бойжсон төлийн тоог нийт гарсан төлийн тоонд харьцуулан 100–гаар үржүүлэн тооцно.

100 эхээс бойжуулсан төл. Бойжуулсан төлийн тоог оны эхний хээлтэгч малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлэн тооцно.

Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо. Хээлтэгч малын тоог хээлтүүлэгч малын тоонд харьцуулж, тооцно. 1 хээлтүүлэгчид ногдох хээлтэгчийн тооны норм нь:

Буур -	20-25
Азарга -	12-15
Бух -	35-45
Хуц, ухна -	25-30

Том малын зүй бус хорогдол дөвчний (халдвартай, халдваргүй) хорогдол, гэнэтийн аюулын (цас зуд, үер ус, гал түймэр, аянга цахилгаан зэрэг) хорогдол, бусад шалтгааны (малын хариулга, арчилгаа маллагаатай холбогдон гарсан) хорогдлыг хамруулна.

Том малын зүй бус хорогдлын оны эхний малд эзлэх хувь. Зүй бусаар хорогдсон том малын тоог оны эхний малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлэн тооцно.

Малын хэрэглээний зарлага.

Оны эхний малын тоон дээр бойжуулсан төлийг нэмж, том малын зүй бус хорогдол, оны эцсийн малын тоог хасч, тооцно.

Малын хашааны хангамж. Хашааны хангамжийг гаргахдаа хашааны багтаамжийг малын тоонд харьцуулж тооцно. Бод малын хашааны хангамжийг гаргахдаа бодын хашааны багтаамжийг үхрийн тоонд, харин бог малынхыг богийн хашааны багтаамжийг бог малын /хонь, ямааны/ тоонд харьцуулж тооцно.

Тэжээл хангамж. Тэжээлийн хангамжийг гаргахдаа тэжээлийн нэгжид шилжүүлсэн тэжээлийн хэмжээг хонин толгойд шилжүүлсэн малын тоонд харьцуулан тооцно. Малын тэжээлийн хангамж, бэлчээрийн даацыг гаргахдаа малыг хонин толгойд шилжүүлснээр тооцно.

Тэжээлийн нэгжид шилжүүлэх коэффициент. Бэлтгэсэн тэжээл нь илчлэг, чанарын байдлаараа харилцан адилгүй байдаг учраас нэг тэжээлийн нэгжид шилжүүлж тэжээлийн хангамжийг гаргана. Үүний тулд:

Хадлан өвс	-	0.45
Таримал тэжээл	-	0.35

Даршны ургамал	-	0.25
Гар тэжээл, хужир шүү	-	1.00
Төмс ногооны хаягдал	-	0.22
Үр тарианы хаягдал	-	0.90
Лай	-	0.40
Сүрэл	-	0.25

гэсэн итгэлцүүрүүдийг ашиглан тэжээлийн нэгжид шилжүүлнэ.

Малын тэжээлийн ангилал. Малын тэжээлийг ургамлын гаралтай, амьтны гаралтай, эрдэс тэжээлийн гаралтай гэж ангилна.

- Ургамлын гаралтай тэжээлд өвс, сүрэл, үр тариа, буурцгийн төрлийн ургамал багтах бөгөөд бүдүүн, хүчит, шүүст тэжээл гэж ангилна.
- 1. Бүдүүн тэжээл- өвс, сүрэл, нэг наст ба олон наст өвс орно.
- 2. Хүчит тэжээл- үр тариа, үр тарианы хаягдал, вандуй, буурцаг орно.
- 3. Шүүст тэжээл - Бүх төрлийн дарш, төмс ногооны хаягдал орно.
- Амьтны гаралтай тэжээлд яс, цусны гурил зэрэг орно.
- Эрдэс тэжээлд давс, хужир шүү орно.

Тариалангийн талбай . Хөдөө аж ахуйн таримал ургамлыг тариалсан талбайг

хэлнэ. Тариалангийн талбайг тариалсан талбай, хураасан талбай, өнжсөн талбай, уринш боловсруулсан талбай гэж ангилна.

Тариалсан талбай. Тухайн жилд үр суулгасан газрын нийт талбайн хэмжээг хэлнэ.

Хураасан талбай. Тухайн жилд ургацыг хурааж авсан газрын нийт талбайн хэмжээг хэлнэ.

Га-гийн ургац. Талбайн нэг нэгжээс /1 га-гаас/ авах газар тариалангийн бүтээгдэхүүний /ургацын/ хэмжээ бөгөөд га-гийн ургацыг тодорхойлохдоо тухайн төрлийн ургамлын хурааж авсан бүх ургацыг тариалсан талбайн хэмжээнд нь харьцуулж тодорхойлно.

Нийт ургац. Тухайн жилд газар тариалангийн үйлдвэрлэл эрхэлж үйлдвэрлэсэн нийт бүтээгдэхүүний хэмжээ, өөрөөр хэлбэл тариалсан бүх талбайгаас хураан авсан үр тариа, төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ, малын тэжээл, техник, тосны ургамал зэрэг ургамал тус бүрийн төрлөөр нэмж гаргасан нийт ургацын хэмжээ болно.

1.МАЛЧДЫНТОО, ТЭДНИЙ СОЁЛ, АХУЙН БАЙДАЛ

1.1. Малчдын тоо, насны бүтэц.

2012 оны жилийн эцсийн мал тооллогоор аймгийн хэмжээгээр 6619 малтай өрх, үүнээс 5131 малчин өрх мал аж ахуйн үйлдвэрлэл эрхэлж байна. Аймгийн хэмжээний нийт өрхийн 37.1 хувийг малтай өрх эзэлж байна.

2012 онд мал аж ахуйн салбарт 9279 малчид ажиллаж байна. Нийт малчдын 47.4 хувь нь буюу 4403 эмэгтэйчүүд байна.

Малчин өрхийн тоо өмнөх оныхоос 5.5 хувиар буюу 300-н өрхөөр, малчдын тоо өмнөх оноос 0.6 хувиар буюу 12 малчнаар буурсан байна. Малчин өрхийн тоо 2000 оноос 2006 хүртэл буурч, 2007, 2008 онуудад өсч байсан боловч 2009 оноос буурах хандлагатай болж байна.

Нийт малчдыг насны бүлгээр нь авч үзвэл 39.8 хувь нь 16-34 насны, 49.0 хувь нь 35-аас тэтгэвэрт гарах насны, 11.2 хувь нь тэтгэврийн насны хүмүүс байна. Эндээс харахад 16-34 насны малчдын тоо өмнөх оноос 459 хүнээр буурч, нийт малчдад эзлэх хувь нь 2.8 хувиар буурч, 35-аас тэтгэвэрт гарах насны малчдын тоо 178 хүнээр өсч харин нийт малчдад эзлэх хувь нь 4.2 хувиар өссөн, тэтгэврийн насны малчдын тоо өмнөх оноос 191 хүнээр буурч нийт малчдад эзлэх хувь нь 1.4 хувиар буурсан байна.


хүснэгт 1

Өрх, малчдын тоо насны бүтэц

	2004	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2012/2011	
										хувь	зөрүү
Малтай өрх	7326	7262	7159	7304	7579	7638	6894	6661	6619	99.4	-42
Малчин өрх	6313	6283	6160	6258	6408	6301	5628	5431	5131	94.5	-300
Малчдын тоо	13358	13152	12053	12261	11926	11612	10258	9751	9279	95.2	-472
Үүнээс:	7173	6938	6468	6492	6049	5614	4640	4154	3695	89.0	-459
16-34 насны											
35-аастэтгэвэрт гарах хүртэл	4050	4236	4236	4187	4433	4677	4388	4366	4544	104.1	178
насны											
Тэтгэврийн	2135	1978	1349	1582	1444	1321	1230	1231	1040	84.5	-191
насны											
Нийт малчдаас эмэгтэй	6020	6301	5807	5818	5649	5453	4809	4598	4403	95.8	-195
Насны бүрэлдэхүүн %	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	0
Үүнээс:	53.7	52.8	53.7	52.9	50.7	48.3	45.2	42.6	39.8	93.5	-2.8
16-34 насны											
35-аастэтгэвэрт гарах хүртэл	30.3	32.2	35.1	34.1	37.2	40.3	42.8	44.8	49.0	109.4	4.2
насны											
Тэтгэврийн насны	16.0	15.0	11.2	12.9	12.1	11.4	12.0	12.6	11.2	88.8	-1.4
Нийт малчдаас эмэгтэй %	45.1	48.1	48.2	47.5	47.4	47.0	46.9	47.2	47.5	100.6	0.3
Нэг малчин өрхөд ногдох малын тоо /толгойгоор/	169	179	187	223	263	278	180	225	276	122.7	51

Нийт сумдад малчин өрхийн тоо буурсан бөгөөд 2012 онд нэг малчин өрхөд 276 толгой мал оногдож байгаа нь өмнөх оноос 51 толгой малаар өссөн байна.

Зураг 1



1.2. Малчдын соёл ахуйн үзүүлэлт .

2012 оны мал тооллогын дүнгээр нийт малчин өрхийн 76.8 хувь буюу 3940 өрх цахилгааны эх үүсгэвэртэй, 74.9 хувь буюу 3841 өрх телевизортой, 46.9 хувь буюу 2405 өрх автомашинтай, 46.9 хувь буюу 2792 өрх мотоциклтой, 0.3 хувь буюу 17 өрх трактортой байна.


Малчдын соёл ахуйн үзүүлэлт

хүснэгт 2

	Өрхийн тоо						Малчин өрхийн тоонд эзлэх хувь					
	2007	2008	2009	2010	2011	2012	2007	2008	2009	2010	2011	2012
Цахилгааны эх үүсвэртэй	4600	5340	5407	5351	5090	3940	73.5	83.3	85.8	95.1	93.7	76.8
Телевизортой	3281	4017	3871	3847	4409	3841	52.4	62.7	61.4	68.4	81.2	74.9
Автомашинтай	1635	1739	1790	1949	2196	2405	26.1	27.1	28.4	34.6	40.4	46.9
Мотоциклтой	3414	3561	3652	3580	3642	2792	54.6	55.6	58.0	63.6	67.1	54.4
Трактортой	43	33	36	46	31	17	0.7	0.5	0.6	0.8	0.6	0.3

2012 онд өмнөх оноос малчин өрхийн тоо буурсантай холбоотойгоор цахилгааны эх үүсгэвэртэй 1150 өрхөөр буюу 16.9 хувиар, телевизортой 568 өрхөөр буюу 6.3 хувиар, автомашинтай 209 өрхөөр буюу 6.5 хувиар, мотоциклтой 850 өрхөөр буюу 12.7 хувиар, трактортой 14 өрхөөр буюу 0.3 буурсан байна.

Зураг 2



2. МАЛ АЖ АХУЙН ТОО, БҮТЭЦ

2.1. Малын тоо.

2012 оны жилийн эцсийн мал тооллогын дүнгээр Өмнөговь аймгийн 15 сумын 58 багт 1.4 сая толгой мал тоолуулж 2012 оныхоос 195.8 мянган толгой малаар буюу 16.0 хувиар өссөн байна. Мал сүрэг таван төрөл дээрээ өссөн үзүүлэлттэй байна.

Тооллогын дүнгээр тэмээний тоо 97317 толгой, адуу 50100 толгой, үхэр 10762 толгой, хонь 299816 толгойд, ямаа 135178 толгойд хүрч өмнөх оныхоос тэмээ 9480 толгойгоор буюу 10.8 хувиар, адуу 6734 толгойгоор 15.5 хувиар, үхэр 2030 толгойгоор буюу 23.2 хувиар, хонь 42372 толгойгоор 16.5 хувиар, ямаа 135178 толгойгоор буюу 16.4 хувиар тус тус өссөн байна.

хүснэгт 3

Малын тоо төрлөөр


	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2012/2011	
									хувь	зөрүү
Бодоор *	292776	298069	340445	393596	411301	289845	330021	376964	114.2	46943
Толгойн тоо	1121524	1155747	1399996	1684939	1755215	1010327	1223459	1419253	116.0	195794
Тэмээ	70846	71654	75361	80789	85692	83765	87837	97317	110.8	9480
Адуу	42751	42197	46431	53036	53683	37621	43366	50100	115.5	6734
Үхэр	8571	8730	10104	12404	13080	7532	8732	10762	123.2	2030
Хонь	246381	252361	296543	351210	375713	212841	257444	299816	116.5	42372
Ямаа	752975	780805	971557	1187500	1227047	668568	826080	961258	116.4	135178

* Бодод шилжүүлэхдээ адуу, үхрийг 1 бод, тэмээг 1.5 бод, 6 хонь, 8 ямааг тус бүр 1 бод гэж тооцов.

Нийт малын өсөлтийн 69.0 хувийг ямаан сүрэг, 21.6 хувийг хонин сүрэг, үлдсэн 9.2 хувийг бод малын өсөлт эзэлж байна.


Малын өсөлтийн хувь

Зураг 3



Малын тоо /мян.толгой/

Зураг 4



Мал тооллогын дүнгээр аймгийн хэмжээнд малын тоо толгой 2005 оноос 2009 он хүртэл өсч 2010 оны цаг агаарын хүнд нөхцлийн улмаас 618.7 мянган мал хорогдож сүүлийн 2 жилд 408.9 мянган толгой малаар өссөн байна.

Малын тооны өсөлт, бууралтанд нөлөөлсөн хүчин зүйл

хүснэгт 4

	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2012/2011	
								хувь	Зөрүү
Бойжуулсан төл	261.5	416.9	486.7	490.5	56.5	406.8	393.6	96.8	-13.2
100 эхээс бойжуулсан төл / толгойгоор /	55	86	90	75	8	78	82	105.1	4.0
Том малын зүй бус хорогдол	40.7	9.9	8.4	30.7	618.7	9.4	8.8	93.8	-0.6
Хээлтэгч малын тоо	484.2	540.1	657	702.0	521.7	477.4	575.1	120.5	97.7
Хээл хаясан хээлтэгч	40.1	4.4	2.3	6.6	12.7	1.9	0.9	47.4	-1.0
Сувайрсан хээлтэгч	105.1	52.2	50.3	105.3	394.9	95.4	79.7	83.5	-15.7

Малын өсөлтөнд нөлөөлдөг гол хүчин зүйл болох бойжсон төлийн тоо өмнөх оноос 13.2 мянган төлөөр буурч, том малын зүй бусын хорогдол өмнөх оноос 584 малаар нэмэгдэж, хээлтэгч малын тоо 2.3 хувиар, хээл хаясан хээлтэгч 52.6 хувиар, сувайрсан хээлтэгч өмнөх оноос 16.5 хувиар буурсан нь малын тоо өсөх үндсэн шалтгаан болсон байна.

2000 оноос хойшхи 13 жилийн малын тооны өсөлт, бууралт

хүснэгт 5

	Бүгд	Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
Өссөн жилийн тоо	8	8	7	8	8	9
Буурсан жилийн тоо	5	5	6	5	5	4
2000 оныхоос өссөн хэмжээ/мян.тол/	-	4.4	-	-	-	92.5
2000 оныхоос буурсан хэмжээ/мян.тол/	70.3		49.0	13.0	105.3	

2000 оноос хойш 13 жилийн 8 жилд малын тоо өсч, 5 жилд нь буурчээ. Энэ хугацаанд нийт малын тоо 70.3 мянган толгойгоор буурч, малын төрлөөр авч үзвэл тэмээ 4.4 мянган толгой, ямаан сүрэг 92.5 мянган толгойгоор өсч, адуу 49.0 мянган толгойгоор, үхэр 13.0 мянган толгойгоор, хонь 105.3 мянган толгойгоор тус тус буурсан байна.

2012 оны байдлаар нийт мал сүргийн 11.5 хувийг бод мал, 88.5 хувийг бог мал эзлэж байна.

Нийт сүрэгт таван төрлийн малын эзлэх хувийг авч үзвэл өмнөх оноос адуун сүргийн хувьд эзлэх хувь нь хэвээр, тэмээн сүргийн хувьд 0.3 хувиар буурч, үхэр сүрэг 0.1 хувиар,

хонин сүрэг 0.1 хувиар, ямаан сүргийн хувьд нийт сүргийн бүтцэд эзлэх хувь нь өнгөрсөн онтой харьцуулахад 0.2 хувиар тус тус өсч, ямаан сүргийн нийт сүрэгт эзлэх хувь нь өндөр хэвээр байна.

Нийт сүрэгт таван төрлийн малыг эзлэх хувь


хүснэгт 6

	2004	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012
Бүгд	100	100	100	100	100	100	100.0	100.0	100.0
Тэмээ	6.6	6.3	6.2	5.4	4.8	4.9	8.3	7.2	6.9
Адуу	3.8	3.8	3.7	3.3	3.1	3.1	3.7	3.5	3.5
Үхэр	0.7	0.8	0.8	0.7	0.7	0.7	0.7	0.7	0.8
Хонь	21.6	22.0	21.8	21.2	20.8	21.4	21.1	21.0	21.1
Ямаа	67.3	67.1	67.6	69.4	70.5	69.9	66.2	67.5	67.7

Бог малын дотор хонин сүргийн эзлэх хувь нь 23.8, ямаан сүрэг 76.2 хувийг тус тус эзэлж байгаа нь уламжлалт харьцаа сүүлийн жилүүдэд ихээхэн алдагдаж байгааг илэрхийлж байна.

Нийт сүрэгт 5 төрлийн малын эзлэх хувь

Зураг 5




Сумдаар авч үзэхэд бог малынх нь 62.6 - 94.0 хувийг ямаан сүрэг эзлэж байна. Манай аймгийн хувьд нийт сүрэгт эзлэх ямааны хувь улсдаа хамгийн өндөр байгаа нь мал сүргийн бүтцэд зохисгүй өөрчлөлт гарч байгаа нь анхаарал татсан асуудал болж байна. Цаашид ямаан сүргийн тоо толгойн өсөлт үргэлжилвэл байгаль орчин, бэлчээрийн хүрэлцээнд муугаар нилээд нөлөөлөх нь тодорхой байна.

Зураг 6



2012 онд нийт мал болон ямааны тоогоор аймагтаа төдийгүй улсдаа Номгон сум, аймагтаа тэмээ, үхэр, хонин сүргийн тоогоор Ханбогд сум, адуун сүргийн тоогоор Манлай сум тус тус тэргүүлж байна.

Зураг 7



Аймгийн хэмжээнд малын тоогоор 7 сум аймгийн дунджаас дээгүүр, 8 сум дунджаас доогуур байна.

2.2 . Хувийн / амины / малын тоо:

2012 онд хувийн малын тоо 1409.2 мянган толгойд хүрч, нийт малын 99.3 хувийг эзлэж байна. Тэмээн сүргийн 99.3 хувь, адуун сүргийн 99.9 хувь, үхэр сүргийн 99.2 хувь, хонин сүргийн 99.0 хувь, ямаан сүргийн 99.3 хувь нь хувийн аж ахуйд байна.

Хувийн малын тоо өмнөх оноос 192.5 мянган толгой буюу 15.8 хувиар өссөн байна.

Хувийн малтай, өрх малын тоо

мян.толгой хүснэгт 7

Он	Малтай өрхийн тоо мян.өрх	Бүгд	Үүнээс:				
			Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
2003	7.4	892.4	69.6	36.6	5.9	199.7	580.6
2004	7.3	1054.1	70.2	40.7	7.3	227.6	708.3
2005	7.3	1105.9	70.3	42.6	8.5	243.4	741.1
2006	7.2	1140.3	70.7	42.1	8.6	249.2	769.7
2007	7.3	1383.8	74.6	46.3	10.0	293.4	959.5
2008	7.6	1666.1	80.0	53.0	12.3	347.2	1173.6
2009	7.6	1738.5	84.9	53.6	12.9	371.7	1215.3
2010	6.9	1002.2	83.2	37.6	7.5	210.4	663.6
2011	6.7	1216.7	87.5	43.4	8.7	255.4	821.8
2012	6.6	1409.2	96.6	50.1	10.7	296.8	954.9

2012 оны байдлаар хувийн аж ахуйн нийт малын 67.8 хувийг ямаа, 21.1 хувийг хонь, 6.9 хувийг тэмээ, 3.5 хувийг адуу, 0.7 хувийг үхэр эзлэж байна.

2.3 Малтай өрхийн малын бүлэглэлт.

2012 оны нийт малтай өрхийн тоонд 10 хүртлэх малтай өрхийн эзлэх хувийн жин нь өмнөх онтой харьцуулахад 1.0 хувиар, 11-30 малтай өрх 1.2 хувиар, 31-50 малтай өрх 1.3 хувиар, 51-100 малтай өрх 1.4 хувиар 101-200 малтай өрх 1.4 хувиар тус тус буурсан, 201-500 малтай өрхийн нийт малтай өрхийн тоонд эзлэх хувийн жин нь өмнөх онтой харьцуулахад 3.2 хувиар, 501-999 малтай өрх 2.6 хувиар, 1000-1499 малтай өрх 0.3 хувиар, 2001-ээс дээш малтай өрх 0.01 хувиар тус тус өссөн байна. Аймгийн хэмжээнд нийт малтай өрхийн 36 хувь нь 100 хүртэлх малтай, 101-200 малтай өрх 23.6 хувийг, 200-аас дээш малтай өрх 40.33 хувийг эзлэж байна.

Малтай өрхийн малын бүлэглэлт

хүснэгт 8

	Малтай өрхийн тоо			Нийт өрхөд эзлэх хувь			Малын тоо /мян.толгой/		
	2010	2011	2012	2010	2011	2012	2010	2011	2012
Бүгд	6894	6661	6619	100	100	100	1002.2	1216.7	1409.2
10 хүртэл малтай	321	214	146	1.1	3.2	2.2	2.1	1.4	1.0
11-30 малтай	922	664	585	6.1	10.0	8.8	18.9	14.0	12.0
31-50 малтай	813	676	582	7.3	10.1	8.8	32.5	27.2	23.6
51-100 малтай	1348	1172	1075	16.4	17.6	16.2	98.2	86.3	79.0

101-200 малтай	1723	1652	1562	24.2	24.8	23.6	245.7	241.2	230.8
201-500 малтай	1544	1907	2104	35.7	28.6	31.8	459.7	590.9	668.9
501-999 малтай	197	329	497	7.9	4.9	7.5	116.9	203.6	316.4
1000-1499 малтай	25	46	66	1.2	0.7	1.0	26.4	50.2	73.6
1500-2000 малтай	1	1	1	0.1	0.02	0.015	1.8	2.0	1.7
2001-ээс дээш	0	0	1	0.01	0.0	0.015	0	0	2.1

1000 ба түүнээс дээш малтай 68 өрх тоологдсон нь 2011 оноос 21-н өрхөөр өссөн байна. 1000-аас дээш малтай өрхийн тоогоор Номгон сум 11 өрхтэй Ханбогд 8 өрхтэй, Сэврэй сум 9 өрхтэй, Баяндалай, Ханхонгор, Хүрмэн, Цогтцэций сум 5 өрхтэй, Мандал-овоо сум тус 4 өрх тоолуулж тэргүүлж байна.

Малтай 1 өрхөд ногдох малын тоо, бүлэглэлтээр

хүснэгт 9

	2010	2011	2012 он					
			2012 он	Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
Бүгд	145	183	213	15	8	2	45	144
10 хүртэл малтай	7	6	7	1	1	1	1	3
11-30 малтай	21	21	20	2	1	1	4	13
31-50 малтай	40	40	41	3	2	0	8	27
51-100 малтай	73	74	74	6	3	1	15	49
101-200 малтай	143	146	148	12	5	1	28	101
201-500 малтай	298	310	318	21	11	2	64	220
501-999 малтай	593	619	637	40	23	5	150	418
1000-1499 малтай	1056	1092	1116	51	47	11	289	717
1500-2000 малтай	1806	1982	1735	0	0	22	313	1400
2001-ээс дээш	0	0	2136	82	63	0	855	1136

Аймгийн дунджаар малтай нэг өрхөд 213 мал оногдож байгаа нь 2010 оноос 70 толгой малаар өссөн байна. Малтай нэг өрхөд 15 тэмээ, 8 адуу, 2 үхэр, 45 хонь, 144 ямаа ноогдож байна. Малтай нэг өрхөд ноогдох малын тоог өмнөх онтой харьцуулахад тэмээ 2 толгой нэмэгдсэн, адуу, үхэр 1толгой, хонь, ямаа 7-21 толгойгоор тус тус өссөн.

2.4 Хээлтэгч мал.

2012 онд 575.2 мянган толгой хээлтэгч тоологдсон нь өмнөх оноос 20.5 хувиар буюу 97.8 мянган толгойгоор өссөн байна. Энэ онд Ингэ 10.5 хувиар гүү 10.5 хувиар, үнээ 10.0 хувиар Эм хонь 23.2 хувиар, Эм ямаа 21.1 хувиар тус тус өссөн 2.9 хувь, ингэ 0.8 хувь, эм хонь 21.4 хувь, эм ямаа 68.6 хувийг тус тус эзэлж байна.

Хээлтэгч малын тоо


	2008	2009	2010	2011	2012	мян.толгой хүснэгт 10	
						2012/2011	
						хувь	зөрүү
Ингэ	26.9	28.2	28.4	30.1	33.3	110.5	3.2
Гүү	14.6	14.6	11.9	13.7	15.1	110.5	1.4
Үнээ	4.8	5.0	3.3	3.8	4.2	110.0	0.4
Эм хонь	143.6	153.3	114.3	102.4	126.2	123.2	23.8

Эм ямаа	467.2	501.0	363.8	327.4	396.4	121.1	69.0
Дүн	657.1	702.0	521.7	477.4	575.2	120.5	97.8

Хээлтэгч мал нь нийт малын 40.5 хувийг эзлэж байгаа бөгөөд тэмээ сүргийн 34.2 хувийг, адуун сүргийн 30.2 хувийг, үхэр сүргийн 39.3 хувийг, хонин сүргийн 42.1 хувийг, ямаан сүргийн 41.2 хувийг тус тус эзэлж байна.


Хээлтэгчийн төрлөөр /хувь/

Зураг 8



Хээлтэгч малын 5.8 хувийг ингэ, 2.6 хувийг гүү, 0.7 хувийг үнээ, 21.9 хувийг эм хонь, 68.9 хувийг эм ямаа эзэлж байна

Зураг 9



Сүүлийн жилүүдэд хээлтэгч малын тоо тогтмол өсч байсан боловч 2010, 2011 онуудад буурч, 2012 онд өссөн байна.

2.5 Төл бойжилт .

2012 онд гарсан төлийн 98.8 хувь нь 393.6 мянган төл бойжуулав. Бойжсон төлийн тоо 2011 онохоос 13.2 мянган толгойгоор буурсан байна.

Төл бойжилтыг төрлөөр нь авч үзвэл гарсан ботгоны 99.5 хувь, унаганы 97.78 хувь, тугалны 98.6 хувь, хурганы 99.4 хувь, ишигний 99.1 хувийг бойжуулсан байна.

Төл бойжилт

	2010	2011	2012	Үүнээс:						хүснэгт 11
				Ботго	Унага	Тугал	Хурга	Ишиг	Хувь	2012/2011
Гарсан	74952	411833	396909	17927	10343	3128	91790	273721	96.4	
Бойжсон	56468	406786	393591	17829	10106	3084	91216	271356	96.8	
Хорогдсон	18484	5047	3318	98	237	44	574	2365	65.7	
Бойжилтын хувь	75.3	98.8	98.8	99.5	97.7	98.6	99.4	99.1	100.0	

2012 онд аймгийн дунджаар 100 эхээс 82 төл бойжуулсан байна. 2012 онд 100 эхээс бойжуулсан төл нь 2011 оноос ингэ, үнээ, эм хонь, эм ямаанаас бойжуулсан төл өсч гүүнээс бойжуулсан төл буурман байна. 100 эхээс бойжуулсан төлийн тоо өнгөрсөн оноос өссөн нь байгаль цаг уурын таатай нөхцөлөөс хээлтэгч болон төлийн хорогдол бага байсантай холбоотой байна.

100 эхээс бойжуулсан төл

	2006	2007	2008	2009	2010	2011	2012	хүснэгт 12
								2012/2011
Бүгд	55	86	90	75	8	78	82	105.1
Ингэ	45	48	56	50	45	45	59	131.1
Гүү	51	74	82	69	13	76	74	97.4
Үнээ	58	75	87	76	25	74	80	108.1
Эм хонь	66	91	95	85	11	87	89	102.3
Эм ямаа	54	88	91	73	5	44	83	188.6

2.6 Том малын зүй бусын хорогдол.


2012 онд оны эхний малын 0.7 хувь нь буюу 8.8 мянган толгой мал хорогдсон нь 2011 оноос 584 толгой малаар буюу 6.2 хувиар буурсан байна. Нийт хорогдсон малын 68.9 хувийг ямаа сүрэг, 24.7 хувийг хонин сүрэг, 2.4 хувийг адуу сүрэг, 3.3 хувийг тэмээ сүрэг, 0.6 хувийг үхэр сүрэг тус тус эзэлж байна. 2012 онд том малын зүй бусын хорогдол өмнөх онтой харьцуулахад буурсан нь нийт малын тоо өсөх үндсэн үзүүлэлт болсон байна.

Том малын зүй бус хорогдол

	2007	2008	2009	2010	2011	2012	2012/2011	хүснэгт 13 зөрүү
Бүгд	9980	8447	30756	618766	9399	8815	93.8	-584
Тэмээ	534	412	484	7027	462	288	62.3	-174
Адуу	267	176	797	13033	336	215	64.0	-121
Үхэр	87	58	356	5269	99	57	57.6	-42
Хонь	2759	2453	7181	135864	2232	2179	97.6	-53
Ямаа	6333	5348	21938	457573	6270	6076	96.9	-194

Сумдаар авч үзвэл нийт сумдуудад хорогдлын хэмжээг **өмнөх онтой харьцуулахад** 90.7-99 хувь буурсан байна.

Зураг 10

**2.7 Малын хээл хаялт, сувайралт.**

2012 онд оны эхний хээлтэгч малын 0.2 хувь нь буюу 978 толгой хээлтэгч хээл хаяж, 16.7 хувьтай тэнцэх 79.7 мянган хээлтэгч сувайрсан байна. Төл өгөөгүй хээлтэгч малын тоо 80.7 мянгад хүрч түүний 98.7 хувийг сувайрсан хээлтэгч, 1.2 хувийг хээл хаясан хээлтэгч мал тус тус эзлэж байна.

Хээл хаяж, сувайрсан хээлтэгч малын тоо

хүснэгт 14

	Хээл хаясан хээлтэгч					Сувайрсан хээлтэгч				
	2008	2009	2010	2011	2012	2008	2009	2010	2011	2012
Бүгд	2370	6587	12755	1904	978	50388	105325	394952	95400	79705
Ингэ	10	80	42	59	21	417	412	751	648	439
Гүү	29	54	323	28	17	2152	3331	7858	2457	3288
Үнээ	12	29	36	8	1	570	749	1704	766	776
Эм хонь	128	406	1366	279	79	10801	15962	79318	15938	14470
Эм ямаа	2191	6018	10988	1530	860	36448	84871	305321	75591	60732

Хээл хаясан хээлтэгч өмнөх онтой харьцуулахад 0.2 хувиар харин сувайрсан хээлтэгч 1.6 хувиар тус тус буурсан байна.

Оны эхний хээлтэгчид хээл хаялт, сувайралтын эзлэх хувь

хүснэгт 15

Бүгд	Оны эхний хээлтэгчид эзлэх хувь									
	Хээл хаясан хээлтэгч					Сувайрсан хээлтэгч				
	2008	2009	2010	2011	2012	2008	2009	2010	2011	2012
Бүгд	0.4	1.0	1.8	0.4	0.2	9.3	16.0	56.3	18.3	16.7
Ингэ	0.0	0.3	0.15	0.2	0.1	1.7	1.5	2.7	2.3	1.5
Гүү	0.2	0.4	2.2	0.2	0.1	16.9	22.9	53.7	20.7	24.0
Үнээ	0.3	0.6	0.7	0.2	0.0	13.6	15.6	34.4	23.2	20.2
Эм хонь	0.1	0.3	0.9	0.2	0.1	8.9	11.1	51.8	13.9	14.1
Эм ямаа	0.6	1.3	2.2	0.4	0.3	9.7	18.2	60.9	20.8	18.6

Хээл хаялт, сувайралт

Зураг 11



2.8. Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо

Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо нь малын бүх төрөл дээр алдагдсан хэвээр байгааг анхаарч үзэх хэрэгтэй байна.

2012 онд 11.6 мянган толгой хээлтүүлэгч мал тоологдож 2011 оноос 13.4 хувь буюу 1382 толгойгоор өссөн байна. Өмнөх онтой харьцуулахад хээлтүүлэгч малын 5 н төрөл дээр өссөн үзүүлэлттэй байна.

Хээлтүүлэгч малын тоо

хүснэгт 16

	Хээлтүүлэгч мал					Үүнээс: Шинээр тавьсан				
	2008	2009	2010	2011	2012	2008	2009	2010	2011	2012
Бүгд	14193	12471	8124	10255	11637	102	30	41	55	37
Буур	927	971	946	961	1000	2	2	2	1	2
Азарга	2476	2468	2073	2226	2379	1	1	1	5	1
Бух	241	196	151	194	205	-	-	-	1	0
Хуц	3546	3147	2115	2708	2977	9	10	10	16	12
Ухна	7003	5689	2839	4166	5076	90	17	28	32	22

Нэг хээлтүүлэгчид оногдох хээлтэгчийн харьцаа тэмээн сүргийн хувьд 20-25 байхад 33, адуун сүргийн хувьд 12-15 байхад 6, үхэр сүргийн хувьд 35-45 байхад 21 байна, харин бог малын хувьд нэг хээлтүүлэгчид ноогдох хээлтэгчийн тоо 25-30 байхад хонь 42, ямаанд 78 байгаа нь үржлийн норм ихээхэн алдагдаж байгааг илтгэж байна.

Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо

хүснэгт 17

	Үржлийн норм	2007	2008	2009	2010	2011	2012
Ингэ	20-25*	27	29	29	30	31	33
Гүү	12-15.*	5	6	6	6	6	6
Үнээ	35-45*	17	20	25	22	20	21
Эм хонь	25-30*	38	40	49	54	38	42
Эм ямаа	25-30*	64	67	88	128	79	78

*-нэг хээлтүүлэгчид ногдох хээлтэгчийн тоо.

2.9 Малын хэрэглээний зарлага.

2012 онд аймгийн хэмжээнд оны эхний малын 15.4 хувь буюу 189.1 мянган толгой малыг хэрэглээнд зарцуулсан байна.

Малын хэрэглээний зарлага 2011 оноос 4.9 мянган толгой малаар өссөн байна. Малтай нэг өрх дунджаар жилд 27 мал үүнээс 1 тэмээ, 0.5 адуу, 0.2 үхэр, 7 хонь, 20 ямааг хэрэглээндээ зориулж зарцуулсан байна. Аймгийн нийт өрхөөр тооцож үзэхэд нэг өрх дунджаар 10.7 толгой малыг хэрэглээндээ зарцуулсан байна.

Малын хэрэглээний зарлага

хүснэгт 18

	2007	2008	2009	2010	2011	2012
Бүгд	162.5	193.2	389.4	182.5	184.2	189.1
Тэмээ	6.8	8.1	8.1	7.7	8.1	8.1
Адуу	3.5	3.6	8.5	4.9	2.9	3.2
Үхэр	1.1	1.2	2.6	1.5	1.1	1.0
Хонь	52.2	57.2	90.8	44.1	52.4	46.7
Ямаа	98.9	122.9	279.2	124.3	119.6	130.1

Оны эхний малд эзлэх хувь


хүснэгт 19

	2007	2008	2009	2010	2011	2012
Бүгд	14.1	13.8	23.1	10.4	18.2	15.4
Тэмээ	9.5	10.9	10.1	9.0	9.7	9.2
Адуу	8.3	7.8	16.1	9.1	7.7	7.3
Үхэр	12.6	12.7	21.1	11.5	15.2	11.4
Хонь	20.7	19.3	25.9	11.7	24.6	18.1
Ямаа	12.7	12.7	23.5	10.1	17.9	15.7

Нийт хэрэглээнд зарцуулсан малын 93.5 хувийг бог мал, 6.5 хувийг бод мал эзэлж байна.

Малын хэрэглээний зарлага /төрлөөр/

Зураг 12



**Зах зээлд худалдаж борлуулсан болон аж ахуйн
дотоодод хэрэглэсэн малын тоо**

хүснэгт 20

	Зах зээлд худалдан борлуулсан					Аж ахуйн дотоодод хэрэглэсэн				
	2008	2009	2010	2011	2012	2008	2009	2010	2011	2012
Бүгд	103076	53635	53635	51245	67047	114660	111818	126912	188493	112893
Тэмээ	2494	3110	3110	3005	4487	3353	3471	3485	3047	3159
Адуу	3315	2105	2105	1764	2016	2281	3007	2434	2071	2114
Үхэр	952	595	595	499	502	935	1519	965	776	769
Хонь	23490	13507	13507	14406	16702	39004	51761	30477	29355	31334
Ямаа	72825	34318	34318	31571	43340	81339	128735	79682	64526	75517

2012 онд зах зээлд худалдан борлуулсан болон аж ахуйн дотоодод хэрэглэсэн нийт малын 37.3 хувийг зах зээлд борлуулж, 62.7 хувийг аж ахуйн дотоодод хэрэглэсэн байна. Малтай нэг өрхөд дунджаар 10 толгой малыг зах зээлд борлуулж, 17 толгой малыг өөрийн хүнсэндээ хэрэглэсэн байна.

2.10 Сүргийн бүтэц.


2012 онд нийт сүргийн 31.2 хувь нь буюу 443.4 мянган толгой нь төл, өсвөр насны мал, 27.4 хувь буюу 389.0 мянган толгой нь нас гүйцсэн эр мал, 40.2 хувь буюу 571.2 мянган толгой хээлтэгч, 1.1 хувь буюу 15.7 мянган толгой хээлтүүлэгч гэсэн бүтэцтэй байна.

2012 оны сүргийн бүтэц

хүснэгт 21

	Толгойгоор /мян.тол/					Нийт сүрэгт эзлэх хувь				
	БҮГД	Төл, өсвөр насны	Ажлын ба бэлтгэлийн насны эр	хээлтэгч	хээлтүүлэгч	БҮГД	Төл, өсвөр насны	Ажлын ба бэлтгэлийн насны эр	хээлтэгч	хээлтүүлэгч
Бүгд	1419.3	443.4	389.0	571.2	15.7	100.0	31.2	27.4	40.2	1.1
Тэмээ	97.3	46.3	16.7	33.3	1.0	100.0	47.6	17.2	34.2	1.0
Адуу	50.1	20.0	12.6	15.1	2.4	100.0	39.8	25.2	30.2	4.7
Үхэр	10.8	5.1	1.2	0.2	4.2	100.0	47.8	11.0	1.9	39.3
Хонь	299.8	95.5	75.2	126.2	3.0	100.0	31.9	25.1	42.1	1.0
Ямаа	961.3	276.5	283.3	396.4	5.1	100.0	28.8	29.5	41.2	0.5

Зураг 13



2.11. Цэвэр үүлдэр болон эрлийз, нутгийн шилдэг омгийн мал.

2012 оны мал тооллогын дүнгээр 46.4 мянган толгой мал нь цэвэр үүлдрийн, 12 толгой мал нь шинэ эрлийз мал, 20.5 мянган толгой мал нь эрлийз мал тооллуулдаг байна.

Цэвэр үүлдэр болон шинэ эрлийз, эрлийз мал

хүснэгт 22

Үүлдрийн төрөл	Хээлтэгч	Хээлтүүлэгч	Бусад	Бүгд
Цэвэр үүлдрийн адуу	16	11	32	59
Цэвэр үүлдрийн тэмээ	2764	95	4077	6936
Цэвэр үүлдрийн үхэр	25	5	12	42
Цэвэр үүлдрийн хонь	611	17	159	787
Цэвэр үүлдрийн ямаа	17978	293	20378	38649
Шинэ эрлийз үхэр	4	0	7	11
Шинэ эрлийз ямаа	0	2	0	2
Эрлийз үхэр	10	1	10	21
Эрлийз хонь	3179	55	4431	7665
Эрлийз ямаа	8877	234	3707	12818

3. Малын бэлчээр, тэжээлийн хүрэлцээ, хангамж**3.1 Бэлчээрийн хүрэлцээ.**

Газрын албаны 2012 ны газрын нэгдмэл сангийн тайлангаар манай аймгийн бэлчээрийн талбай 11.3 сая га талбайд хүрч малын тоо хонин толгойд шилжүүлснээр 2.0 сая толгойд хүрч 2011 оноос 270.7 мянган толгой малаар өссөн байна.

2012 онд 100 га талбайд хонин толгойд шилжүүлснээр 18 толгой мал ногдож байна.

Бэлчээрийн хүрэлцээ

хүснэгт 23

	2006	2007	2008	2009	2010	2012	2012/2011
Бэлчээрийн талбай /мян.га/	11463.4	11455.5	11455.5	11426.1	11372.2	11372.2	100.0
Хонин толгойд шилжүүлсэнээр 100 га бэлчээрийн талбайд ногдох малын тоо	17	20	21	13	16	18	112.5

100 га бэлчээрийн талбайд ногдох хонин толгойд шилжүүлсэн малын тоо 2011 оныхоос 2 малаар өссөн байна.

Зураг 14



Манай аймгийн хувьд бэлчээрийн талбай их байгаа хэдий ч ус худгийн хүрэлцээ хангамж муу, мөн малчдын суурьшил ихтэй газруудад ашигт малтмалын болон хайгуулын лицензтэй ААНэгжүүд үйл ажиллагаа явуулж байгаагаас малын бэлчээрийн хүрэлцээ багасаж байна.

3.2 Малын тэжээлийн үйлдвэрлэлт.

2012 онд аймгийн хэмжээгээр 4909.79 тонн хадлан, 17.9 тонн таримал тэжээл, 803.3 тонн гар тэжээл, 37.5 тонн даршны ургамал 801.6 тонн хужир шүү, 83.6 тонн төмс, ногооны хаягдал хураан авч бэлтгэсэн байна. Тухайлбал хадлан 2011 оноосоо 37.9 хувиар, даршны

ургамал 463.1хувиар, гар тэжээл 82.6 хувиар, төмс ногооны хаягдал 63.6 хувиар өсч, хужир шүү 58.6 хувиар, таримал тэжээл 43.9 хувиар буурсан байна.

Өөрийн хүчээр бэлтгэсэн хадлан нэр, төрлөөр

хүснэгт 24

	2008	2009	2010	2011	2012	2012/2011
Хадлан өвс	4568.2	1522.8	3081.1	3561.1	4909.79	137.9
Таримал тэжээл	206.9	219.7	266.6	31.9	17.9	56.1
Даршны ургамал	10.1	8.3	9.4	6.66	37.5	563.1
Гар тэжээл	2178.5	435.3	518.3	439.9	803.3	182.6
Хужир шүү	3368.5	1975.7	1337.5	1937.9	801.6	41.4
Төмс, ногооны хаягдал	33.1	33.7	59.6	51.1	83.6	163.6
Үр тарианы хаягдал	-	-	-	-	2	-
Лай	-	-	-	-	-	-
Сүрэл	-	-	75.1	-	6	-

Зураг 15



Үйлдвэрлэсэн тэжээлийг бүтцээр нь авч үзвэл бүдүүн тэжээл 42.9 хувиар, шүүст тэжээл 109.7 хувиар өсч, бусад тэжээлийн хэмжээ 58.6 хувиар, хүчит тэжээлийн хэмжээ 37.6 хувиар, буурсан үзүүлэлттэй байна. Хонин толгойд шилжүүлснээр 1 малд оногдох тэжээлийн хэмжээ 3.2 байна.

3.3 Тэжээлийн бүтэц, тэжээлийн хангамж

хүснэгт 25

	2008	2009	2010	2011	2012	2012/2011
Бүгд	10365.3	4195.5	5272.5	6028.56	6661.69	114.3
Хүчит	206.9	219.7	266.6	31.9	19.9	62.4
Шүүст	43.2	42.0	69.0	57.8	121.1	209.7
Бүдүүн	6746.7	1958.1	3599.4	4001.0	5719.1	142.9
Бусад	3368.5	1975.7	1337.5	1937.9	801.6	41.4
Хонин толгойд шилжүүлсэн нэг малд ноогдох тэжээл тэж.кг	4.5	1.7	3.4	3.3	3.2	97.1

Бэлтгэсэн тэжээл нь илчлэг, чанарын байдлаараа харилцан адилгүй байдаг учраас нэг тэжээлийн нэгжид шилжүүлж тэжээлийн хангамжийг тооцлоо. Тэжээл бүрээр тодорхой итгэлцүүр ашиглан тэжээлийн нэгжид шилжүүллээ.

4.Тэжээвэр амьтан**4.1 Тэжээвэр амьтадын тоо**

2012 нд 295 гахай, 1599 шувуу, 3 илжиг тоологдсон нь 2011 оноос 56 гахайгаар буюу 23.4 хувиар өсч харин шувуу 923 шувуугаар буюу 36.6 хувиар буурсан байна.

Тэжээвэр амьтадын тоо

хүснэгт 26

	2009	2010	2011	2012	2012/2011	
					Хувь	Зөрүү
Гахай	135	175	239	295	123.4	56
Шувуу	1524	213	2522	1599	63.4	-923
Илжиг	4	3	4	0	0.0	-4
Гахайтай өрхийн тоо	10	15	18	18	100.0	0
Шувуутай өрхийн тоо	8	11	9	9	100.0	0
Илжигтэй өрхийн тоо	4	3	3	3	100.0	0

Дүгнэлт

Өмнөговь аймгийн хэмжээнд 2012 оны хувьд 6619 малтай өрхийн мал сүрэг 1419.2 мянган толгойд хүрч 2011 оныхоос таван төрөл дээрээ 195.8 мянган толгой малаар буюу 16.0 хувиар өссөн. Энэ нь 2011-2012 оны байгаль цаг уурын таатай нөхцөл байдалтай холбоотойгоор том малын зүй бусын хорогдол 8.8 мянгад хүрч өнгөрсөн оноос 601 толгой малаар буурсан, төл бойжилт 99.2 хувьтай байгаа нь мал сүрэг өсөхөд нөлөөллөө. 2012 оны нийт малын 67.7 хувийг ямаан сүрэг эзэлж байна. Таван төрлийн малын уламжлалт харьцаа алдагдаж цаашлаад бэлчээрийн даацад хүндээр тусах магадлал өндөр байна.

2012 онд нийт сүргийн 11.2 хувийг бод мал, 88.8 хувийг бог мал эзэлж байна. Нийт бог малын дотор 76.2 хувийг ямаан сүрэг, 23.8 хувийг хонин сүрэг эзлэж байна. Нийт мал сүрэгт эзлэх ямаан сүргийн тоо жилээс жилд өсөн нэмэгдэж байна. Энэ нь 75.0 хувьд хонь, 25.0 хувь нь ямаа байх уламжлалт харьцаа маш их алдагдаж эсрэгээрээ болсон байна.

Өнөөгийн байдлаар аймгийн хэмжээнд нийт 5131 нь малчин өрхөд 9279 малчин байгаа бөгөөд эдгээрийн 662 өрх нь 50 хүртэлх малтай, 4012 нь 51-500 малтай, 557 нь 501 –ээс дээш малтай байна. Мал аж ахуйн салбарын үйлдвэрлэлд гарч байгаа өсөлт нь малын тооноос хамаарч байгаа бөгөөд цаашид нэг малын ашиг шим, чанарын үзүүлэлтэд анхаарлаа хандуулж, энэ чиглэлээр тодорхой арга хэмжээг үе шаттайгаар авч хэрэгжүүлэх нь шаардлагатай байна. Ялангуяа мал аж ахуйн салбарт шинэчлэл хийж, ашиг шим өндөртэй мал өсгөж үржүүлэх, малыг суурин болон бэлчээрийн хосолсон маллагаанд шилжүүлэх, малчдын хөдөлмөрийг хоршуулах, бэлчээрийг усжуулахад чиглэсэн арга хэмжээ ихээхэн чухал байна.

Мал аж ахуйн салбарын өсөлтөд байгаль цаг уурын таатай нөхцөл ихээхэн нөлөөлж байгаа боловч үүний зэрэгцээ малын гаралтай түүхий эдийн үнийн өсөлт нөлөөлсөн байна. Үүний хажуугаар мал эмнэлгийн үйлчилгээ орхигдож, удмын сан сүргийн бүтцийн харьцаа алдагдаж, өндөр ашиг шим өгдөг цэвэр эрлийз үүлдрийн малын тоо цөөрсөн, малын чанар муудсан зэрэг хүндрэлтэй асуудлууд байна.

Өдгөө мал сүрэг маань эргээд эрчимтэй өсч үржиж байгаа бөгөөд бэлчээрийн мал аж ахуйг цаашид хөгжүүлэхдээ бэлчээрийн даац, сүргийн бүтцээ зөв тохируулан, чанаржуулж өсгөх бодлогыг баримтлах хэрэгтэй байна.

Манай аймаг байгаль цаг агаар, газар нутгийн хувьд бусад аймгуудаас харьцангуй өвөрмөц онцлоготой бөгөөд ХАА-н салбар нь нийтдээ байгалиас шууд хамааралтай, эрчимжсэн аж ахуйн хөгжил сул байгаа зэрэг нь энэ салбарын цаашдын хөгжлийн талаар бодлого төлөвлөгөөтэй ажиллах зайлшгүй шаардлага урган гарч байгаа юм. Түүнчлэн ажилгүйдэл ядуурлын түвшинг байнга хэлбэлзүүлж байдаг энэ салбарт зах зээлийн өнөөгийн нийгэмд зохицсон бодлого хөтөлбөр гарган системтэйгээр хэрэгжүүлэх нь зүйтэй юм.

Тус аймаг социалист системийн үед инженерийн хийцтэй 12 услалтын системийн 250 га талбай, нийтдээ 450 га талбайг тариалангийн зориулалтаар ашиглаж төмс, хүнсний ногоо, тэжээлийн ургамал, жимс жимсгэнэ тариалж байсан бол 2012 оны байдлаар 177 га талбайд тариалалт хийсэн байна. .

Аймгийн хэмжээгээр 2012 онд 65,8 га-д төмс, 48,1 га-д хүнсний ногоо, 63,1 га-д малын тэжээлийн ургамал тариалж, 636,8 тонн төмс, 474,4 тонн хүнсний ногоо, 281 тонн тэжээлийн ургамал хураан авсан байна. Ер нь газар тариалангийн үйл ажиллагаанд байгаль, цаг уур ихээр нөлөөлж байгаа боловч цаашид ургац хураалтын хэмжээг боломжийн хэмжээнд байлгахын тулд га-гийн ургацыг нэмэгдүүлэх, үүний тулд чанартай сайн уринш боловсруулалтыг нэмэгдүүлэх, усалгаатай талбайн хэмжээг нэмэгдүүлэх, таримал ургамалын сортын үрийг үйлдвэрлэх замаар ганд тэсвэртэй хүнсний болон тэжээлийн таримлын үрийг үржүүлэх, сортын үрээр хангах, ургац боловсролтын үед хортон шавьжтай тэмцэх зэрэгт ихээхэн анхаарах шаардлагатай байна.

Сүүлийн 10 жил тус аймгийн газар тариалангийн салбар өсөлт бууралттай явж ирсэн бөгөөд тариалалт, хураан авсан ургац буурч байгаа нь ган зудын давтамж, усан хангамжийн хүрэлцээ дутмаг болсны дээр удирдлага менежменттэй холбоотой асуудлууд нэлээдгүй байна.

АЙМГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

Хавсралтуудын жагсаалт

1. Малтай өрх, малчин өрхийн тоо
2. Малчдын тоо, нас хүйсний бүрэлдэхүүн
3. Малчдын соёл ахуйн үзүүлэлт, малчин өрхийн тоонд харьцуулсан хувиар
4. Малтай өрхийн бүлэглэлт
5. 2012 онд малынхаа тоогоор эхний 5-т орсон сум, малчид
6. 2012 оны жилийн эцэст тоологдсон нийт малын тоо
7. 2012 оны жилийн эцэст тоологдсон малын өсөлт бууралт
8. Малтай нэг өрхөд ногдох малын тоо
9. 2012 оны эцэст байгаа амины малын тоо, түүний өсөлт бууралт
10. Нийт сүргийн бүтэц
11. Тэмээн сүргийн бүтэц
12. Адуун сүргийн бүтэц
13. Үхэр сүргийн бүтэц
14. Хонин сүргийн бүтэц
15. Ямаан сүргийн бүтэц
16. Хонин толгойд шилжүүлсэн малын тоо
17. Хээлтэгч малын тоо, түүний өсөлт бууралт
18. Нийт сүрэгт хээлтэгч малын эзлэх хувь
19. Нийт бойжуулсан төл, бойжилтын хувь
20. 100-н эхээс бойжуулсан төл
21. Том малын зүй бусын хорогдол, оны эхний малд эзлэх хувь
22. Гэнэтийн аюулаас хорогдсон малын тоо
23. Хээл хаясан хээлтэгч, оны эхний хээлтэгчид эзлэх хувь
24. Сувайрсан хээлтэгч, оны эхний хээлтэгчид эзлэх хувь
25. Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо
26. Малын хэрэглээний зарлага, оны эхний малд эзлэх хувь
27. Зах зээлд худалдан борлуулсан, аж ахуйн дотоодод хэрэглэсэн малын тоо
28. Сарлагын тоо
29. Бэлтгэсэн өвс
30. Бэлтгэсэн гар тэжээл
31. 2012 оны малжуулалтын тайлан
32. 2012 онд шинээр гаргасан худгийн тайлан
33. 2012 онд засварласан худгийн тайлан

Хавсралт 1

МАЛТАЙ ӨРХ, МАЛЧИН ӨРХИЙН ТОО сумдаар

	Малтай өрхийн тоо			Малчин өрхийн тоо			Малтай өрхөд ноогдох малын тоо		
	2010	2011	2012	2010	2011	2012	2010	2011	2012
Дүн	6894	6658	6619	5628	5431	5131	147	184	214
Баяндалай	516	491	489	427	410	396	180	220	254
Баян-Овоо	396	351	367	286	276	290	118	179	205
Булган	387	375	371	340	329	320	143	193	236
Гурвантэс	754	745	749	569	568	538	134	147	169
Мандал-Овоо	351	331	331	325	305	302	136	184	224
Манлай	519	518	523	464	463	462	139	170	196
Номгон	625	601	592	516	499	473	187	250	291
Ноён	292	286	286	261	246	229	239	264	285
Сэврэй	477	465	452	362	342	336	186	210	232
Ханбогд	667	672	658	480	478	385	144	167	187
Ханхонгор	481	472	471	439	408	375	129	180	219
Хүрмэн	383	369	376	362	350	356	159	214	243
Цогт-Овоо	282	280	277	238	241	234	109	144	183
Цогтцэций	345	351	366	302	306	263	99	127	146
Даланзадгад	419	351	311	257	210	172	83	107	156

Хавсралт 2

МАЛЧДЫН ТОО, НАС ХҮЙСНИЙ БҮРЭЛДЭХҮҮН сумдаар

	Малчдын тоо /15-дээш насны/			Үүнээс:			Нийт малчдаас эмэгтэй
	2010	2011	2012	15-34 настай	35-59 эр 30-54 эм настай	Эр - 60, Эм - 55-с дээш	
Дүн	10258	9751	9279	3695	4544	1040	4403
Баяндалай	756	746	710	213	403	94	345
Баян-Овоо	516	491	494	192	253	49	243
Булган	675	624	615	253	286	76	305
Гурвантэс	1023	996	974	393	463	118	463
Мандал-Овоо	599	556	566	215	298	53	246
Манлай	860	784	828	396	363	69	396
Номгон	949	916	901	386	426	89	424
Ноён	472	441	412	162	215	35	182
Сэврэй	691	657	630	266	309	55	297
Ханбогд	882	875	701	293	363	45	332
Ханхонгор	754	728	665	244	326	95	310
Хүрмэн	662	642	620	268	285	67	295
Цогт-Овоо	433	435	424	167	212	45	206
Цогтцэций	531	517	450	168	202	80	216
Даланзадгад	455	343	289	79	140	70	143

МАЛЧДЫН СОЁЛ АХУЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТҮҮД сумдаар

Хавсралт 3

Дүн	Багийн тоо	Цахилгаан эх үүсвэртэй өрх	Үүнээс :				Телевизортой өрх	Малын хашаатай өрх	Худагтай өрх	Машины тоо	Мотоциклийн тоо	Трактортой		Хийсэн эсгий	Радиотой өрх
			Нарны	Салхины	Бага оврын мотор	Бусад						Өрхийн тоо	Тракторын тоо		
	58	4157	3940	413	518	24	3841	3936	3626	2405	2792	31	31	8256	2198
